

БОРИЛГЫН
ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

БАТЛАВ

Н.ХОНГОРЗУЛ

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлгийн гадна фасадны засварын ажил

Нэгдсэн эмнэлгийн барилга: Тус сургуулийн барилга нь А, Б, В, гэсэн 3 блоктой А блок нь 4 давхар, тэнхлэгээрээ 18.0м х 78.0м хэмжээтэй, Б блок нь 4 ба 5 давхар, тэнхлэгээрээ 18.0м х 42.0м хэмжээтэй, В блок нь 2 ба 3 давхар, тэнхлэгээрээ 48.0м х 48.0м хэмжээтэй, 400 мм зузаантай угсармал хавтгаалжин керамзит бетон ханатай, хавтгай дээвэр бүхий хийц бүтээцтэй барилга болно.

А. Дорноговь аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгын гадна фасадны засварын ажлыг дараах Барилгын норм ба дүрэм /БНБД/ стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх.

Б. Ажил гүйцэтгэх хугацааны график /хөдөлмөр зарцуулалт, үргэлжлэх хугацаа, ажиллах хүчний тоо/-ийг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

В. Талбайн зохион байгуулалтын зураг, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааг хангах төслийн баримт бичгийг тухайн ажилд нийцүүлэн боловсруулах

Г. Үнийн саналд төсөвт өртөгийн дүн **54 352 400** төг, тусган ирүүлэх ба "Барилгын төсөв зохиох дүрэм" БНБД 81-95-12*(2020)-г мөрдлөг болгоно.

1. Буулгалтын ажил:

- Цонх, хаалганы хайрцаг задалж, шавардлагыг ховхлох. Хаалгатай шилэн хана буулгах, хана буулгаж цонх суух нүх, зай гаргах.
- Төмөр бетон хавтгаалжин ханын заадас хоорондын хөндийрч муудсан шавардлага, цонхны амалгааны хөндийрсөн шавардлага, цонхны усны хаялага төмөр, цонхны хамгаалалтын төмөр сараалж, "В" блокийн цонх хоорондын дулаалгатай хөнгөн хана, барилгын хананд хадаж бэхэлсэн нэр хаяг, гэрэлтүүлэг, цахилгаан тоноглолууд, агааржуулалтын хоолой, цонхны усны хаяалга төмөр зэрэг фасадны дулаалга, өнгөлгөөний ажлыг хийхэд саад болох тоноглолуудыг буулгаж буцаан ашиглах тоноглолыг ашиглагч талд түр хадгалуулаад угсралтын ажлыг бүрэн дууссаны дараа дахин тоноглож ашиглалтын шаардлага хангана.

2. Гадна фасадны ажил:

- Барилгын үндсэн хананд 50 мм зузаантай хавтгаалжин шилэн хөвөн дулаалгыг 2 үе хийнэ. Шилэн хөвөнгийн дулаан дамжуулах чанар $K=3,0 \text{ м}^2 \text{ ОС/ВТ}$ -аас багагүй байна. Дулаалга хийхийн өмнө бэхэлгээний деталл буюу кроштэйнийг ажлын зурагт заасан зай хэмжээний дагуу бэхэлсэн байна. Эхний 1-р үеийн шилэн хөвөн хавтгаалжийг хананд цавуут зуурмагаар нааж байрлуулсны дараа зам төмөр буюу профилийг урьдчилсан байрлуулсан бэхэлгээний деталлд бэхлэнэ. Үүний дараа 2-р үеийн шилэн хөвөн хавтгаалжийг дюбелийн тусламжтай бэхлэнэ. Дулаалга хийсэн хананд ажлын зурагт заасан өнгийн металл хавтанг угсарна.
- Цоколь, шатны хонгил, подвалын хашлага хана, тамбурын ханын завсарт 20 мм зузаан цементэн шохойн зуурмагаар шавардлага хийнэ. Цоколь, шатны хонгил, хашлага хана, тамбурын ханын гадаргууд суурь цавуун хөрсжүүлэгч түрхэнэ.

Цоколь, шатны хонгил, тамбурын хананд фактуран өнгөлгөө хийнэ. Цоколь, шатны хонгилын хана, тулгуур багана, саравч, шат довжоо, орц гарцны хашилга хана, дээврийн прапедний хийцүүдийг сайн чанарын ус чийгэнд тэсвэртэй эмульсэн будгаар 2 үе давхарлаж будна. Дээвэрт гарах гарцны байгууламжийн гадна хананд 100 мм хөөсөнцөр хавтангаар дулаалж,

- тэгшилгээ өнгөлгөөг хийж зурагт заасан өнгийн сайн чанарын ус чийгэнд тэсвэртэй эмульсэн будгаар 2 үе давхарлаж чанартай будна.

- "В" блокын консолийг доороос нь хөөсөнцөр хавтангаар дулаалж, тортой хар замаск хийж, ус чийгэнд тэсвэртэй эмульсэн будгаар 2 үе давхарлан будах. "А, В" блокийг холбосон хүзүүвний доод талд 150 мм зузаантай эрдэс хөвөн хавтангаар дулаалж, төмөр лампиран хавтангаар өнгөлгөө хийх.

- "В" блокийн 16-18-р тэнхлэгийн В-Ж тэнхлэгийн хооронд "А" блокийн "Ж" тэнхлэгийн дагуу 1-12-р тэнхлэг хооронд мөн 3-К тэнхлэгийн 11-18-р тэнхлэг хоорондох хэсгүүдэд байрдах 2.84 м түвшинд дулаалга өнгөлгөөг хийнэ.

- Бетон хаяавч цутгах БМ100 маркийн бетоноор 20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх.

- Ажлын үе шат бүрд фото зураг авч баталгаажуулна.

3. Хаалга, цонхны ажил:

- Барилгын цонх нь Монголд улсад мөрдөж буй БНБД 23-02-09 норм, MNS-5830:2007 MNS-5802:2007 стандарт дулаан техникийн шаардлага хангасан байна. Резин жийргэвч нь ISO 9001 стандартын шаардлагыг хангасан байна.

- Ажлын зурагт заасан хэмжээний хуванцар рамтай 2 давхар шилэн багцтай, салхижуулалттай, рам нь 70 мм-ээс багагүй өргөнтэй резинэн жийргэвч нь чанарын шаардлага хангасан цонхыг угсарч, гадна талын амалгааг нь цементэн зуурмагаар сайн чанартай шавардаж өнгөлгөө заслалын ажлыг гүйцэтгэнэ.

- Цонхны тавцанг суулгахдаа цонхноос 5% -ийн налуутайгаар амалгааны шавардлагад 20-30 мм суулгаж, дотор ханаас 40-50 мм өнгийлгөн суулгана.

- "В" блокийн цонх хооронд гадна ханын хэмжээтэй адил зузаантай шохойн блокоор дөр хана өрж барилгын үндсэн хананд анкер төмрийн тусламжаар хүчитгэн бэхлэж, гадна дотор талаас нь сайн чанартай шавардаж, дотор талаас нь заслын ажил хийнэ. Цонхныдоод хэсэгт 200 мм түвшинд өрлөг арматурчилж өрөх.

- Эмнэлгийн гол орц, хүүхдийн тасаг, яаралтай тусламжийн гадна хаалга нь цайрдсан металл рамтай хатжуулсан 2 давхар шилэн багцтай, дотор, гадна талруугаа онгойдог нугастай, савалтаас хамгаалсан татуурган нугастай, босгогүй байна. Бусад гадна хаалга нь модон самбартай чанар сайтай байна.

- Хаалга цонхыг эрх бүхий байгууллагаар хийлгэж угсруулах эсвэл импортын материал худалдан авах тохиолдолд чанартай бат бөхийг сонгон хэрэглэх шаардлагатай. Хаалга, цонхыг захиалахдаа газар дээрээс бодит хэмжээг авах шаардлагатай. Хаалга, цонхны гадна ханатай харьцах хэсгийг шингэн хөөсөн дулаалгаар сайтар чигжиж, амалгаа хийнэ.

- Ажлын үе шат бүрд фото зураг авч баталгаажуулна.

Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь:

1. Барилгын засварын ажлыг батлагдсан зураг төсөл, ажлын тоо хэмжээний дагуу чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж,

БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

3. Барилгын засварын ажлыг эхлүүлэхдээ иргэдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулах, хашаа барих зэрэг шаардлагатай арга хэмжээг авч гэнэтийн аюул осол гаргахгүй байхаар ажиллана.

4. Импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ, лабораторийн шинжилгээний дүн, үнийн баримтыг хавсаргана.

5. Барилгын талбайд ажлын журнал, батлагдсан зураг төсөл, хэрэглэгдэж буй материалын лабораторийн сорилтын дүн, тохирлын гэрчилгээ, гарал үүслийн бичиг баримтуудыг бэлэн байлгах шаардлагатай.

6. Гүйцэтгэсэн ажил тус бүрд ил, далд ажлын акт бичиж, схем зураг, фото зургаар баталгаажуулсан байна.

7. Барилгын ажлыг чанаргүй гүйцэтгэсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.

8. Барилгын зураг төсөлд зааснаас зайлшгүй тохиолдолд өөрчлөлт оруулах болвол захиалагч болон зураг төслийн байгууллагатай зөвшилцөнө. Зөвшөөрөлгүйгээр газар дээр өөрчлөхийг хориглоно.

9. Хэрэв материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.

10. Гүйцэтгэгч нь барилгын ажлын ил, далд ажлын актыг баталгаажуулах, үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл хөтлөх, барилгын улсын хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, зураг төсөл зохиогч, захиалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг бүрэн биелүүлнэ.

11. Энэхүү техникийн тодорхойлолтод заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч эрхийнхээ дагуу барилгын ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй болно.

12. Монгол Улсын “Барилгын тухай” хуулийн 14.3-т /барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна/ 14.4-т /14.3-т заасан хугацаа дуусгавар болсон тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, захиалагч болон ашиглагч тухайн барилга байгууламжид хамтарсан үзлэг хийж, зөрчлийг арилгах талаар тэмдэглэл үйлдэнэ/ 14.5-д /14.4-т заасны дагуу зөрчлийг арилгаснаар 14.3-т заасан хугацаа дуусгавар болсонд тооцно/ 14.6-д /14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа3-аас доошгүй жил байна/ гэж заасныг үндэслэн гүйцэтгэгч байгууллага **чанарын баталгаа** гаргаж өгнө.

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ ХЯНАСАН:

АЗДТГ-ЫН ХБТХОХ-ИЙН ДАРГА

/Ц.МӨНХ-ЭРДЭНЭ/

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:

АЙМГИЙН ГХБХБГ-ЫН БХБХ-ИЙН ДАРГА

/Ц.БАЯРМАА/